


Сүрьеэгийн тодорхойлолт




1 Сүрьеэ гэж юу вэ?

- Сүрьеэгийн нянгаар үүсгэгддэг, амьсгалын замаар халдварладаг халдварт өвчин юм. Ихэвчлэн уушгинд үүсдэг ч биеийн бусад эрхтэн системд ч өвчин үүсгэдэг.



2 Сүрьеэ хэрхэн тархдаг вэ?

- Уушигны сүрьеэгээр өвчилсөн өвчтөн ханиах, найтаах, ярих үед сүрьеэгийн нян агаарт цацагдаж, агаар дуслын замаар өөр хүний уушгинд орсноор сүрьеэгийн нян халдварлагдана.



АСУУЛТ БА ХАРИУЛТ (Q&A)

KOREA DISEASE CONTROL AND PREVENTION AGENCY



KOREAN (한국어)



MONGOLIAN (몽골어)

Q1 Сүрьеэгийн эмчилгээний зардал нь хэд вэ?

A1 Эрүүл мэндийн даатгалд даатгуулагч

Сүрьеэгийн эмчилгээ дуусах хүртэл бүх эмчилгээ нь **үнэ төлбөргүй**.

* Гэхдээ, хоолны төлбөр, зарим эрүүл мэндийн даатгал үйлчилдэггүй эмчилгээний зардлыг хувь хүн өөрөө хариуцна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүн

Сүрьеэгийн эмчилгээний бүх зардлыг **өөрөө төлөх** ёстой ч эрүүл мэндийн төв эсвэл Сүрьеэгийн үндэсний төв эмнэлэг* үнэ төлбөргүй эмчлүүлэх боломжтой.

* Гэхдээ, хоолны төлбөр болон зарим эрүүл мэндийн даатгал үйлчилдэггүй эмчилгээний зардлыг хувь хүн өөрөө хариуцана.

* Богино хугацааны эсвэл шаардлага хангаагүй оршин суух хугацаандаа олон эмэнд дасалтай сүрьеэтэй гэж оношлогдвол бусдад халдвар тараах хугацаа нь дуусах хүртэлх эмчилгээг батлагдсан төсвийн хэмжээнд сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хамрагдах боломжтой.

Сүрьеэгийн үндэсний төв эмнэлгийн мэдээлэл


Масан сүрьеэгийн үндэсний төв эмнэлэг



Кёнсаннам, Чанвон-ши
Масанхаппо- гу, Гапо-ро, 215

☎ 055-249-5051

Мугпу сүрьеэгийн үндэсний төв эмнэлэг



Жолланам, Мугпу-ши,
Синжимаыл 1-гил 75

☎ 061-280-1114

Q2 Би эх орондоо очиж сүрьеэ өвчнөө эмчлүүлмээр байна. Солонгос рүү дахин эргэн ирэх боломжгүй юу?

A2 Үгүй. Нутаг буцаж эмчилгээг хийлгүүлээд, эмчилгээ дуусгасан нь батлагдвал* дахин Солонгост орж ирэх боломжтой.

* БНСУ-аас Монгол улсад суугаа ЭСЯ(Консул)аар дамжуулан сүрьеэгийн эмчилгээ хийлгээд эдгэрсэн болохыг батлах бичиг авах

Q3 Сүрьеэгийн эмчилгээг дур мэдэн зогсоосон эсвэл эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд яах вэ?

A3 Солонгост сүрьеэгийн эмчилгээний явцад "эмчилгээг дагахгүй" эсвэл "эмчилгээгээ зогсоох" тохиолдолд **анхаарал хяналт тавих хүн ийн бүртгэлд бүртгэгдэнэ**.

Харьяа эрүүл мэндийн төвөөс албадан хэвтүүлэх арга хэмжээ авах ба нутаг буцсан нь* тогтоогдвол дахин хил нэвтрэхийг хориглох** арга хэмжээ авах болно.

* Харьяа эрүүл мэндийн төв нь Солонгосын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх агентлаг(эсвэл Гадаадын иргэн, харьяатын газар)аар дамжуулан хилээр гарсан, орсон тухай лавлагааг шүүж, нуцаг буцсан эсэхийн шалгана.

** Нутагтаа сүрьеэгийн эмчилгээ хийлгээд эдгэрсэн (БНСУ-аас Монгол улсад суугаа ЭСЯ(Консул)аар дамжуулан авсан эмчилгээ хийлгээд эдгэрсэн болохыг батлах бичиг) болох нь батлагдвал хилээр нэвтрэх хоригийг цуцлах боломжтой.

Сүрьеэгийн халдвар авсан гадаад иргэдэд зориулсан

'Сүрьеэ'-ГИЙН

ЭМЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ГАРЫН АВЛАГА



Tuberculosis

KDCA
Korea Disease Control and Prevention Agency

결핵 ZERO

의치가능한
결핵
Ministry of Health

Сүрьеэгийн илрүүлэлтийн үзлэг шинжилгээ

KOREA DISEASE CONTROL AND PREVENTION AGENCY



1 Сүрьеэгээр өвчилсөн үед ямар шинж тэмдэг илрэх вэ?



14хоног ба түүнээс дээш хугацаагаар ханиалгах



жин буурах



халуурах



шөнөөр хөлрөх



бие сульдах



хооллох дур багасах г.м

2 Сүрьеэгийн шинж тэмдэг илэрвэл яах ёстой вэ?

- Ойрхон эрүүл мэндийн төв болон эмнэлэгийн байгууллагад очиж сүрьеэгийн илрүүлэлтийн үзлэг шинжилгээнд хамрагдана уу.

Сүрьеэгийн илрүүлэлтийн үзлэг шинжилгээний үнэ төлбөр

Эрүүл мэндийн төв



Үнэ төлбөргүй

Эмнэлэгийн байгууллага



Үзлэгт хамрагдагч төлөх

3 Сүрьеэгийн илрүүлэлтийн үзлэгээр ямар шинжилгээ хийх вэ?



1 Цээжний рентген шинжилгээ

- Сүрьеэ өвчнийг оношлох үндсэн шинжилгээ юм.
- Шинжилгээний хариу “сэжигтэй” гэж гарвал цэрний шинжилгээгээр сүрьеэ эсэхийг шалгана.



2 Цэрний шинжилгээ

- Сүрьеэгийн нянг илрүүлэх зорилготой шинжилгээ юм.
- Сүрьеэтэй гэж оношлогдсон бол заавал эмчилгээ хийлгэнэ.

Сүрьеэгийн эмчилгээ

KOREA DISEASE CONTROL AND PREVENTION AGENCY



1 Эмэнд мэдрэг сүрьеэ

- Сүрьеэ нь бсараас дээш хугацаагаар тасралтгүй эмчилгээ хийлгэвэл бүрэн эдгэрдэг. Эмчилгээний явцад шинж тэмдэг сайжрахаар эм уухаа зогсоох болон эмнэлэгт үзүүлэхгүй бол сүрьеэ өвчин дахих магадлалтай тул эмчлэгч эмч эмчилгээгээ дууссан гэх хүртэл эмчилгээ хийлгэх ёстой.

ҮН

Isoniazid

ҮН

Rifampin

ҮН

Ethambutol

PZM

Pyrazinamide

bcwp

Tubes Tab.

* Эмэнд мэдрэг сүрьеэг эмчлэх эмнүүд



- Халдварт сүрьеэтэй өвчтөний халдвар хяналтын удирдамж

- Агааржуулалт сайтай, тусдаа өрөөг ганцаараа хэрэглэх
- Ханиаж, найтаахдаа ам, хамраа салфеткаар дарах, хэрэглэсэн салфеткаа тагтай хогийн саванд хаях
- Эмчилгээ хийлгэх зэргээр гадаа гарахдаа заавал маск зүүх

2 Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээ

- Олон эмэнд дасалтай сүрьеэ нь эмчлэгдэхэд төвөгтэй бөгөөд энгийн сүрьеэтэй харьцуулахад илүү урт(6- 20сар)хугацаагааны эмчилгээ шаардагддаг.Туршлагатай мэргэжлийн эмчээр эмчилгээ хийлгэхийг зөвлөж байна.

- Олон эмэнд дасалтай сүрьеэ гэж юу вэ?

Олон эмэнд дасалтай сүрьеэ нь сүрьеэгийн эсрэг түгээмэл хэрэглэдэг хүчтэй хоёр эмэнд(изониазид, рифамипицин) дасалтай болохыг хэлнэ.

- Олон эмэнд дасалтай сүрьеэ яагаад үүсдэг вэ?

Өвчтөн анхнаасаа олон эмэнд дасалтай сүрьеэгийн нянгийн халдвар авах эсвэл эмчийн өгсөн эмийг тогтмол уугаагүй, эмчилгээг бүрэн хийлгээгүй тохиолдолд үүсдэг.

- Олон эмэнд дасалтай сүрьеэгийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн байгууллагын мэдээлэл

